



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2020 оны 05 сарын 29 өдөр

Дугаар A/89

Ховд

Тооллогын комисс томилох тухай

Монгол Улсын “Төрийн болон албаны нууцын тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалт, “Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журам”-ын 2 дугаар бүлгийн 2.1.4, 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт ашиглагдаж байгаа онц чухал-маш нууц, маш-нууц, нууц ном материал, данс бүртгэлийн 2020 оны хагас жилийн тооллогыг 06 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд зохион байгуулж явуулсугай.

2. Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

Б.Ганхуяг - Цэргийн штабын дарга, хурандаа

Гишүүд:

Б.Мөнгөнцоож -Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт,  
сургалтын офицер, хошууч

Д.Одгэрэл -Дайчилгааны офицер, хошууч

3. Онц чухал-маш нууц, маш-нууц, нууц ном материал, данс бүртгэлийг нэг бүрчлэн хуудас бүрээр нь тоолон, дүнг 06 дугаар сарын 03 -ны дотор танилцуулан, актыг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлэхийг комиссын дарга /хурандаа Б.Ганхуягт /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

02 00491  
D/Tush-A/89-Da